



АРХАНГАЙ АЙМГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

АРХАНГАЙ АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ НИЙГМИЙН БАЙДЛЫН ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА

2018/06



www.nso.mn www.arkhangai.nso.mn www.1212.mn




ЭРҮҮЛ МЭНД

Эмнэлгийн байгууллагууд 519 ор, амбулаторийн 111 их эмчтэйгээр хүн амд үйлчилж давхардсан тоогоор 166.0 мянган хүнд амбулаторийн үзлэг хийсний 59.4 мянгад нь урьдчилан сэргийлэх үзлэг хийж 11.3 мянган хүнийг эмнэлэгт хэвтүүлэн эмчилж гаргасан байна.

Вакцинжуулалтанд хамрагдвал зохих 0-2 насны хүүхдийн 98.8 хувийг бүрэн хамруулсны дотор Чулуут, Хангай, Цэцэрлэг, Хайрхан, Батцэнгэл, Өлзийт, Өгийнуур, Цахир сумд 100,0 хувь хамруулсан байна.

Амаржсан эх, амьд төрсөн хүүхдийн тоо, жил бүрийн эхний 6 сарын байдлаар



Оны эхний 6 сард 881 эх төрж, 883 хүүхэд амьд төрсөн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 6,7 хувиар буюу 63 хүүхдээр бага байна,

Хүн амын нас баралт 267 гарсан нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 59 тохиолдлоор буюу 28,3 хувиар их байна. Мянган хүнд ноогдох төрөлт 9,3, нас баралт 2,8 ноогдож хүн амын ердийн цэвэр өсөлт 6,5 промил байна. Төрөхийн улмаас

эндсэн эхийн эндэгдэл 1 гарч, 1-5 насны хүүхдийн эндэгдэл 5, нялхсын буюу 0-1 насны хүүхдийн нас баралт 19 гарч мянган амьд төрөлтөд 21,5 ногдож байна.

Эндсэн хүүхдийн тоо, жил бүрийн эхний 6 сарын байдлаар



Аймгийн дүнгээр арван мянган хүн тутмаас 31 нь буюу 294 хүн халдварт өвчнөөр өвчилсөн байгаа бөгөөд Батцэнгэл(45), Эрдэнэбулган(50), Булган (48), Ихтамир (55), Өндөрүлаан (35), сумдад аймгийн дунджаас дээгүүр бусад сумдад аймгийн дунджаас доогуур байна. Халдварт өвчнөөр өвчлөгсдийн 16,7 хувь нь салхин цэцгээр, 42,9 хувь нь бэлгийн замын халдварт өвчнөөр, 13,9 хувь нь сүрьеэгээр, 26,5 хувь нь бусад халдварт өвчнөөр өвчилсөн байна. Халдварт өвчний гаралт өнгөрсөн оны мөн үеийнхээс 8,0 хувиар буюу 22 тохиолдлоор нэмэгдсэн байна.



АЖИЛГҮЙДЭЛ, АЖЛЫН БАЙР


7 дугаар сарын 1-ний байдлаар хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгэлтэй ажил идэвхтэй хайж байгаа 1324 ажилгүй хүн байгаагийн 51,7 хувь нь буюу 685 нь эмэгтэйчүүд байна. Хөдөлмөрийн насны 10,0 мянган хүн тутамд 228 ажилгүйчүүд

ноогдож байгаа бөгөөд өнгөрсөн оны мөн үеийнхээс бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 4,6 хувиар нэмэгдсэн байна. Бүртгэлтэй ажилгүйчүүдийн 98,3 хувь нь боловсролтой иргэд байгаагийн 191 нь дээд, 63 нь тусгай дунд болон мэргэжлийн анхан шатны, 986 нь бүрэн болон бүрэн бус дунд, 61 нь бага боловсролтой хүмүүс байна.

6 дугаар сард ажилгүйчүүдийн бүртгэлд 366 хүн шинээр бүртгүүлж, 242 хүн ажил идэвхитэй хайхаа больсноос идэвхигүй болж 166 хүн ажилд зуучлуулан орсон байна.

Оны эхний 6 сард аймгийн дүнгээр 580 ажлын байр шинээр бий болгосон байна. Шинэ ажлын байрыг сумдаар үзвэл Эрдэнэбулган сум 278, Эрдэнэмандал, Булган, Цэнхэр, Ихтамир, Хангай, Жаргалант сумд 22-39 ажлын байрыг, Чулуут, Өлзийт, Өндөрүлаан, Хайрхан сумд 16-20 ажлын байрыг, Цэцэрлэг, Батцэнгэл, Хашаат, Өгийнуур, Төвшрүүлэх сумд 10-14 ажлын байрыг, Цахир, Тариат сумд 3-5 ажлын байрыг бий болгожээ.

Ажлын шинэ байранд ажилд орсон иргэний тоо





НИЙГМИЙН ДААТГАЛ ХАЛАМЖ

Нийгмийн даатгалын сангийн орлого оны эхний 6 сард 25,5 тэрбум төг, зарлага 25,1 тэрбум төг болж өмнөх оныхоос орлого 1489,7 сая төг буюу 6,2 хувиар, зарлага 1719,0 сая төг буюу 7,4 хувиар өслөө.


Нийгмийн даатгалын сангийн орлого өмнөх оныхоос 1489,7 сая төгрөгөөр өсөхөд тэтгэврийн даатгалын сангийн орлого 13,5 хувиар, тэтгэмжийн даатгалын сан 12,8 хувиар тус тус өссөн нь нөлөөлсөн байна.

Нийгмийн даатгалын сангийн зарлага өмнөх оныхоос 7,4 хувиар өсөхөд тэтгэврийн даатгалын сан 13,1 хувиар, тэтгэмжийн даатгалын сан 18,8 хувиар, ҮОМШӨ-ний даатгалын сан 5,2 хувиар өссөн нь шууд нөлөөлөв. Тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэрт 13,1 мянган хүнд 22,9 тэрбум төгрөг, тэтгэмжийн даатгалын сангаас бүх төрлийн тэтгэмжид 1132 хүнд 864,1 сая төгрөгийг олгосон байна.

Оны эхний 6 сард нийгмийн халамжийн сан болон хүний хөгжил сангаас давхардсан тоогоор 19,0 мянган хүнд 5653,7 сая төгрөгийн тэтгэмж хөнгөлөлт тусламж, хишиг олгосон байна. Нийгмийн халамж үйлчилгээгээр олгосон нийт мөнгөний 58,8 хувь нь нийгмийн халамжийн сангаас олгосон халамжийн тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмж, хөнгөлөлт, 41,2 хувийг улсын төсвөөс олгосон тэтгэмж тусламж эзэлж байна.

Нийгмийн халамжийн сангаас олгосон мөнгөний 55,1 хувийг халамжийн тэтгэврээр, 28,7 хувийг нөхцөлт мөнгөн тэтгэмжээр, 16,2 хувийг ахмад настан хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгосон болон хүнс тэжээлийн хөнгөлөлт тусламжид зарцуулж байна.

Нийгмийн халамжийн сангаас олгосон, тэтгэвэр, тэтгэмжийн бүтэц




ГЭМТ ХЭРЭГ

Аймгийн хэмжээгээр 156 хүн гэмт хэрэгт холбогдож 280 гэмт хэрэг гарсны дотор хүний амь бие эрүүл мэндийн эсрэг хэрэг 104, өмчлөх эрхийн эсрэг 125, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг 12, байгаль хамгаалах журмын эсрэг 11, бусад 28 хэрэг гарсан байна.


Гэмт хэргийн улмаас 9 хүн нас барж, 116 хүн гэмтэж бэртэн улс болон иргэдэд 564,4 сая төгрөгийн хохирол учирсан байна. Бүртгэгдсэн нийт хэргийн 9,6 хувийг бүлэглэж 12,9 хувийг согтуугаар үйлдсэн байгаа ба зөрчил гаргасан 307 хүнийг албадан саатуулж 130 хүнийг баривчилсан байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, гэмт хэрэгт холбогдогчийн тоо, жил бүрийн эхний 6 сарын байдлаар



Өнгөрсөн оны мөн үетэй зэрэгцүүлэхэд бүртгэгдсэн гэмт хэргийн тоо 8,9 хувиар буюу 23 тохиолдлоор өссөний дотор хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 31,6 хувиар буюу 25 тохиолдлоор өсч харин өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 3,1 хувиар буюу 4 тохиолдлоор буурсан байна.

Гэмт хэргийн улмаас гэмтсэн, нас барсан хүний тоо, жил бүрийн эхний 6 сарын байдлаар






ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО ЗАРЛАГА

Улсын төвлөрсөн төсвийн шилжүүлэг дэмжлэгийг оруулан тооцсоноор 2018 оны эхний 6 сард аймгийн төсөвт 11562,7 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 12739,7 сая төгрөгийн орлого оруулж төлөвлөгөөг 110,2 хувиар биелүүлсэн байна.

Улсын төсвийн шилжүүлэг дэмжлэгийг оруулахгүйгээр аймаг өөрөө 2878,4 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээс 4055,4 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлэн төлөвлөгөөг 140,9 хувиар биелүүллээ. Төсвийн орлогын төлөвлөгөөг бүх сумд 107,6 хувиас 4,9 дахин биелүүлсэн байна.

Орон нутгийн төсвийн орлогын бүтэц, хувиар



Орлогыг нэр төрлөөр нь үзвэл ойгоос хэрэглээний мод түлээ ашигласны төлбөр, ус рашааны төлбөр, түгээмэл тархацтай байгалийн баялаг ашигласны төлбөр, бууны татвар, хог хаягдлын үйлчилгээний хураамжаас бусад нэрийн орлогуудыг 107,8 хувиас 5,3 дахин биелүүлсэн байна.


Аймгийн төсвийн орлогын 68,2 хувийг тусламжийн орлогоор, 18,1 хувийг орлогын албан татвараар, 1,3 хувийг өмчийн татвараар, 2,1 хувийг тусгай зориулалтын орлогоор

/АТӨХЭрэгслийн/, 5,0 хувийг бусад албан татвараар, 3,8 хувийг татварын бус орлогоор, 1,5 хувийг хөрөнгийн орлогоор бүрдүүлж байна.

Улсын төвлөрсөн төсөвт аж ахуй нэгжийн орлогын татвараар 129,2 сая төгрөг, нэмэгдсэн өртгийн албан татвараар 570,3 сая төгрөг, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр 134,8 сая төгрөг, агаарын бохирдлын төлбөрөөр 19,0 сая төгрөг бүгд 853,3 сая төгрөгийг шилжүүлж даалгаврыг 2,4 дахин давуулан биелүүллээ.

Орон нутгийн төсвийн байгууллагуудын зарлагын хэмжээ 31761,0 сая төгрөг байгаагийн 52,1 хувийг цалин хөлсөнд, 6,2 хувийг нийгмийн даатгалын шимтгэлд, 41,7 хувийг бараа үйлчилгээ болон бусад зардалд зарцуулжээ. Эдийн засгийн салбараар харвал 32,9 хувийг нийтийн ерөнхий үйлчилгээнд, 56,7 хувийг боловсролын салбарт, 9,4 хувийг эрүүл мэндийн салбарт, 0,6 хувийг барилга хот байгуулалтын салбарт, 0,4 хувийг бусад салбарт зарцууллаа.

Орон нутгийн төсвийн байгууллагын нийт зарлагын бүтэц, хувиар






МӨНГӨ ЗЭЭЛ, ХАДГАЛАМЖ

Манай аймагт арилжааны 4 банкны салбар иргэд аж ахуй нэгж байгууллагуудад үйлчилгээ үзүүлж байна. Монгол банкны мэдээгээр арилжааны банкууд монгол банкнаас зузаатгалаар 18,9 тэрбум төгрөгийг авч 16,0 тэрбум төгрөгийг гүйлгээнээс эргүүлэн татсан байна.

Оны эхний 6 сард банкууд 31,0 мянган иргэд, аж ахуй нэгжид 70,6 тэрбум төгрөгийн зээл олгосон байна.

Иргэдийн хадгаламжийн үлдэгдэл, олгосон зээлийн хэмжээ, жил бүрийн эхний 6 сарын байдлаар сая.төг



Өнгөрсөн оны мөн үеийнхтэй зэрэгцүүлэхэд иргэдийн хадгаламжийн үлдэгдэл 23,6 хувиар, олгосон зээлийн хэмжээ 5,5 хувиар өссөн байна. Харин анхаарал хандуулах зээлийн хэмжээ 39,4 хувиар, чанаргүй зээлийн хэмжээ 30,8 хувиар нэмэгдсэн байна.



ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ

2018 оны 6 дугаар сард бараа үйлчилгээний үнэ тариф өмнөх сарынхаас өөрчлөгдөөгүй, өнгөрсөн оны мөн үеийнхээс 4,6 хувиар, 2017 оны 12-р сарынхаас 3,4 хувиар, 2015 оны 12-р сарынхаас 14,2 хувиар тус тус өссөн байна.

Өнгөрсөн 5 дугаар сартай зэрэгцүүлэхэд хэрэглээний сагсанд авсан 238 нэрийн бараа үйлчилгээний үнэ тарифын 4,1 хувийнх нь өсч, 4,0 хувийнх нь үнэ буурч 91,9 хувийнх нь үнэ тогтвортой байлаа. Тухайлбал өмнөх сарынхаас өөхөн тос, хорхой ааруул, савласан сүү, өндөг тахианы мах, алим, давс, эрээн даавуу зэргийн үнэ 0,1-3,2 хувиар буурч харин адуу, хонь, ямаа, үхрийн мах, архи, пиво, тамхи, аяга таваг, лаа, гэрийн цагаан бүрээс, мотоцикл зэргийн үнэ 0,1 – 3,6 хувиар нэмэгдсэн байна,

Харин өмнөх оны мөн үетэй зэрэгцүүлэхэд 4,2 хувийнх нь буюу 10 нэрийн бараа үйлчилгээний үнэ буурч, 27,0 хувийнх нь буюу 65 нэрийн бараа үйлчилгээний үнэ тариф өсч, 68,8 хувийнх нь үнэ тогтвортой байна.


Өнгөрсөн оны мөн үеийнхээс ямааны мах, тахианы мах, дотор мах, өөхөн тос, сармис, улаан лооль, цемент зэргийн үнэ 0,2-8,6 хувиар буурч харин үхэр адууны мах, цагаан будаа, тараг, шар тос, өндөг, амтлагч, манжин лууван, алим, эрэгтэй эмэгтэй хүний гадуур, дотуур хувцас, гутал, ботинк, саван, хадаас, мотоцикл, бүх төрлийн шатахуун зэрэг барааны үнэ 0,2- 23,2 хувиар нэмэгдсэн байна.



ХӨДӨӨ АЖ АХУЙ

7 дугаар сарын 1-ний байдлаар оны эхний хээлтэгч малын 79,9 хувь нь буюу 1786,0 мянган эх мал төллөж гарсан төлийн 93,2 хувь нь буюу 1664,4 мянган төл бойжиж байна. Төл бойжилтыг малын төрлөөр үзвэл гарсан ботгоны 88,3 хувь, унаганы 93,1 хувь, тугалын 94,1 хувь хурганы 94,4 хувь, ишигний 90,2 хувь нь бойжиж байна.

Сумдаас Чулуут, Төвшрүүлэх, Жаргалант, Тариат сумд гарсан төлөө 97,1 – 98,8 хувиар бойжуулж байна.




Өнгөрсөн оны мөн үеийнхээс аймгийн дүнгээр төллөсөн эх мал 4,3 хувиар, бойжиж байгаа төлийн тоо 7,2 хувиар бага, төлийн хорогдол 63,7 хувиар их байна.

Эхний 6 сарын байдлаар оны эхний мал 94,4 хувиар онд орж оны эхний малын 5,6 хувь буюу 298,8 мянган том мал хорогдов. Хорогдсон малын 10,4 хувийг адуу, 18,9 хувийг үхэр, 40,6 хувийг хонь, 30,1 хувийг ямааны хорогдол эзэлж байна.

Сумдаас Хотонт, Цэнхэр, Өгийнуур, Хашаат, Өлзийт, Батцэнгэл сумдын оны эхний малын 6,9- 13,6 хувь нь, Цахир, Хайрхан, Ихтамир, Төвшрүүлэх, Булган, Өндөрүлаан, Хангай, Эрдэнэбулган сумдын оны эхний малын 3,0- 5,5 хувь нь, бусад сумдын малын 0,3-2,7 хувь нь хорогдсон дүнтэй байна.

Зүй бусаар хорогдсон малын тоо бүтэц, төрлөөр



Энэ хавар 6913,1 га-д үр тариа, 252,0 га-д төмс, 104,6 га-д хүнсний ногоо, 1466,8 га-д малын тэжээлийн ургамал, 1178 га-д техникийн ургамал тус тус тариалаад байна.

Өнгөрсөн оны энэ үеийнхтэй зэрэгцүүлэхэд үр тариа 10,3 хувиар, төмс 47,4 хувиар, техникийн ургамал 15,8 хувиар, хүнсний ногоо 39,2 хувиар, тэжээлийн ургамал 19,9 хувиар тус тус бага тариалсан байна.

2018 онд манай аймаг ойгоос 96,6 мянган м3 галын түлээ, 11,1 мянган м3 хэрэгцээний мод, бүгд 107,7 мянган м3 мод авч ашиглахаар баталсанаас оны эхний 6 сард 32,2 мянган м3 галын түлээ, 6,8 мянган м3 хэрэгцээний мод, бүгд 39,0 мянган м3 мод бэлтгэж хэрэглэсэн байна. Бэлтгэсэн модны гоожингийн орлогоор 126,0 сая төгрөг төсвийн орлогод оруулсан байна.



АЖ ҮЙЛДВЭР

Үйлдвэрийн газрууд 2018 оны эхний 6 сард оны үнээр 3276,7 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж

борлуулсан нь өнгөрсөн оныхоос 7,2 хувиар илүү байна. Зэрэгцүүлэх үнээр үнэлснээр 1082,3 сая төгрөгийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 2,7 хувиар их байна.

Нийт үйлдвэрлэлтийн 9,9 хувийг хүнс ундааны, 1,0 хувийг хэвлэлийн, 61,6 хувийг дулааны эрчим хүчний, 15,3 хувийг усан хангамж, 3,8 хувийг модон эдлэлийн, 5,9 хувийг гутал хувцасны, 2,5 хувийг бусад үйлдвэрлэл эзэлж байна.

Гол нэрийн бүтээгдэхүүнээс талх, нарийн боов, хэрчсэн гурил, түгээсэн болон савласан цэвэр ус, дулаан, зүсмэл, монгол гутлын үйлдвэрлэл 2,6- 41,8 хувиар нэмэгдлээ. Харин савхин гутал, монгол дээл, вакуум цонхны үйлдвэрлэлийн хэмжээ 0,3 – 41,9 хувиар буурсан байна.



Эхний хагас жилд барилгын байгууллагууд 1398,3 сая төгрөгийн барилга угсралтын ажил хийгээд байна. Энэ нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 34,6 хувиар бага байна.

Тээврийн байгууллагууд 26,3 мянган зорчигч, 21,7 мянган тонн ачаа тээвэрлэн 12,2 сая хүн км, 1,8 сая ткм ажил гүйцэтгэн 216,8 сая төгрөгийн орлоготой ажиллаа. Өнгөрсөн

оны мөн үеийнхээс зорчигч, зорчигч эргэлт, ачаа, эргэлт, орлогын хэмжээ 2,6 -189,7 хувиар нэмэгдлээ.

Холбооны байгууллагууд 406 телефон цэг улс, хот хоорондын телефон, интернет, телевизийн үйлчилгээгээр байгууллага иргэдэд үйлчилж сумдад 7 хоногт 1-2 удаа шуудан хүргэж нийт 148,1 сая төгрөгийн орлоготой ажилласан нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 1,3 хувиар буурсан байна.



ЦАГ УУРЫН БАЙДАЛ

6 дугаар сард агаарын дундаж температур 13,8-аас 20,2 хэм байсан бөгөөд хамгийн их дулаан Хашаат, Өлзийт, Өгийнуур, Хайрхан сумдад 32,0 хэм хүрч байсан бол хамгийн хүйтэн нь Өндөрүлаан, Хангай, Тариат, Өндөрүлаан, Цахир, Булган сумдад -1,0-аас -4,0 хэмд хүрч хүйтэрч байсан байна.

Энэ сард Булган, Эрдэнэбулган, Чулуут сумдын нутгаар 72,2-99,7 мм хур тундас орсон нь хамгийн их тундастай байгаа бол Хайрхан, Цахир сумдад 9,8 – 17,6 мм хур тундас орсон нь хамгийн бага байна.

Статистикийн хэлтэс
2018.07.11